

БАЯНТАЛ СУМЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Говьсүмбэр аймгийн Баянтал сум нь хуучнаар Сэцэн хан аймгийн Боржигин Сэцэн вангийн хошууны хоймор нутаг юм.

БНМАУ-ын Бага хурлын 1990 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 34-р тогтоолоор Зөвлөлтийн цэргийн ангийн хотхоныг түшиглүүлэн Улаанбаатар хотын харьяа Баянтал хороо нэртэйгээр 1991 оны 1-р сард байгуулагдсан. Улсын бага хурлын 1991 оны 6-р сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолын дагуу 1991 оны 7-р сараас Чойр хотын Баянтал хороо болж, улмаар 1994 онд Засаг захиргааны шинэ бүтэц зохион байгуулалтанд орсоноор Говьсүмбэр аймгийн Баянтал сум болон байгуулагдсан. Засаг захиргааны анхан шатны нэгж болох 2 багтай.

Дулаан хангамж: Сумын төв нь төвлөрсөн халаалттай, Инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон давуу талтай. Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 9 жилийн 4 дүгээр сургууль, 4 дүгээр цэцэрлэг, Соёлын төв, “Талын Илч” ОНӨҮГазар зэрэг бүх байгууллагууд, айл, өрхийн орон сууц нэгдсэн дулаантай, цэвэр бохирын шугаманд бүрэн холбогдсон.

Сумын төвд угсармал 5 давхар 6 барилга буюу 690 өрхийн 1-4 өрөө байртайгаас одоогоор 2 барилга нь ашиглалтанд орсон нэгдсэн инженерийн бүрэн хангамжтай.

Улаанбаатар хотоос 200 км-т

Аймгийн төвөөс 27 км зайд байрладаг.


Төмөр замын 14, 16, 18-р зөрлөгүүдийг харьяалж, баруун талаараа Дундговь аймгийн Цагаандэлгэр, хойд талаараа Төв аймгийн Баян, Баянжаргалан, зүүн, урд талаараа Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум зэрэг сумдуудтай хиллэдэг.

Байгаль, Газар зүйн онцлог: Далайн түвшинээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд тал хээрийн мужид, геоморфологийн хувьд говь, хээрийн бүсэд багтах бөгөөд улаан хүрэн шавранцар хөрстэй.

Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Сумын 2017 оны болон өмнөх жилүүдтэй харьцуулсан статистик үзүүлэлтүүд

Баянтал сумын нийт хүн амыг сүүлийн 3 жилээр харьцуулбал



Сумын нийт хүн ам	1240
Эрэгтэй	630
Эмэгтэй	610
Нийт өрх	418

1-р баг нийт хүн ам	790
Эрэгтэй	387
Эмэгтэй	406
Нийт өрх	258




2-р баг нийт хүн ам	450
Эрэгтэй	243
Эмэгтэй	207
Нийт өрх	160

Сумын нийт мал сүргийн тоо			
Огноо	1-р баг	2-р баг	Нийт
2016	28533	30588	59121
2017	28972	37369	66341
Өсөлт / бууралт	-4390	6781	7220

Нийт мал сүргийг 5н төрлөөр нь авч үзвэл					
Огноо					
2016	141	4162	2094	28374	24350
2017	149	4639	2006	32031	27516
Өсөлт	8	477	-88	3657	3166

Сумын санхүүгийн талаар зарим нэг мэдээлэлүүд

2017 оны Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



Төсвийн байгууллагуудын 2017 оны батлагдсан төсөв зарцуулалт, 2018 оны төсөв

№	Байгууллагын нэр	2017 оны төлөвлөгөө	2017 оны гүйцэтгэл	Дутуу санхүүжилт	Үлдэгдэл төвлөрүүлэлт	2018 оны батлагдсан төсөв
1	ИТХурал	45,062.6	43,745.7	405.6	911.3	38,269.3
2	ЗДТГазар	235,981.8	234,131.8	1,655.5	194,5	242,642.4
3	ЭМТөв	234,375.7	233,372.70	0	1,003.0	246,903.8
4	4-р сургууль	432,124.9	425,199.60	0	6,925.3	436,587.6
5	4-р цэцэрлэг	162,598.3	158,399.40	0	4,198.9	167,369.8
6	Соёлын төв	58,295.5	57,584.20	0	711.3	62,331.8
Нийт дүн		1,168,438.8	1,152,433.4	2,061.1	13,944.3	1,194,104.7

Сумын орон нутаг хөгжил сангийн талаар 2017 онд хийгдсэн ажил, 2018 оны батлагдсан төсөв

ОНХСангийн 2018 оны батлагдсан төсөв

Байгууллагын нэр	Урьд оны үлдэгдэл	2017 оны санхүүжилт	2017 оны дансны үлдэгдэл	2018 онд аймгаас санхүүжих дүн	Нийт батлагдсан төсөв
1 ОНХСан	231,301.9	45,249.5	24,357.3	55,344.7	79,702.0

2016 оны үлдэгдэл ажил

Д / д	Үзүүлэлт	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
3. Зураг төсөв /Зөвлөх үйлчилгээ/				
	4-р сургуулийн дотуур байрны засвар	49,862,8	49,784,2	
	4-р сургуулийн дотуур байрны засвар / нэмэлтээр /	5,033,1	4,923,4	100
	152-р байрны өмнө тоглоомын талбай байгуулах тохижилт авто зогсоолын ажил	125,385,9	125,385,9	100
	Шинээр худаг барих ажил	18,000,0	9,500,0	50
	Нийт дүн	180,281,9	180,093,5	

ТОСТ БОРЖИГОНЫ ТӨРГӨН ХОЙМОР

2017 онд ОНХСангаас хийгдсэн ажил үйлчилгээ

Д/д	Үзүүлэлт	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1. Ажил/ Их засвар, барилга угсралт				
1	4-р сургуулийн спорт заалны цахилгаан монтажны ажил	8,800,000	8,800,000	100
2	Суманд интернет тавих	5,000,000	5,000,000	100
3	Сумын соёлын төвд цэвэр бохир усны шугам тавих	7,000,000	7,000,000	100
4	Авто зогсоол нэмэлтээр	4,000,000	4,000,000	100
Нийт дүн		24,800,000	24,800,000	
2. Бараа /тоног төхөөрөмж/				
1	Сумын эрүүл мэндийн төвийн түргэн оношилгооны тоног төхөөрөмж	3,000,000	3,000,000	100
2	4-р сургуулийн дотуур байрны хүүхдийн зөөлөн эдлэл	3,725,000	3,725,000	100
3	4-р цэцэрлэгийн 100 хүүхдийн зөөлөн эдлэл	2,500,000	2,500,000	100
4	4-р сургуульд ширээ сандал /30 ширхэг/	6,600,000	6,600,000	100
5	4-р цэцэрлэгийн бүлгийн тоглоом	5,000,000	5,000,000	100
Нийт дүн		20,825,000	20,825,000	
Д/д	Үзүүлэлт	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
3. Зураг төсөв /Зөвлөх үйлчилгээ/				
1	Өргөх станцын зураг төсөв.	10,000,000	3,000,000	70
2	2-р багийн төвийн барилгын зураг төсөв	4,800,000	2,400,000	70
Нийт дүн		14,800,000	5,400,000	
4. Хөтөлбөр Төсөл арга хэмжээ				
1	Гамигаас хамгаалах зардал	5,190,500	5,190,500	100
2	Сумын баяр наадмын зардал	5,000,000	5,000,000	100
3	Мод тарих, ногоон байгууламж бий болгох услалтын иланк	885,000	885,000	100
4	Нохой устгал, сумын туурь хог хаягдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ, зардал	5,000,000	5,000,000	100
5	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт	5,000,000	5,000,000	100
6	Малыг бүртгэлжүүлэлтэнд хамруулах ээмэгний мөнгө	2,384,740	2,384,740	100
7	Зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр	2,069,000		0
Нийт дүн		25,529,240	23,460,240	

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн их засвар

Д/д	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Хүлээн авсан эсэх
1	Спорт заалны засвар	40,000,0	40,000,0	Хүлээн авсан
2	Соёлын төвийн дээвэр засвар	40,000,0	40,000,0	Хүлээн авсан

ТОСТ БОРЖИГОНЫ ТӨРГОН ХОЙМОР

2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөгөөр батлагдаж он дамжин 2017 онд хэрэгжсэн ажлууд:

1. Ажлын нэр: 4-р сургуулийн дотуур байрны засвар

Гэрээний дүн: **49,862,830 төгрөг**

Нэмэлт ажлын гэрээний дүн: 5,033,170 төгрөг

Гүйцэтгэгч байгууллага: **Харвайн толгой ХХК**

Санхүүжилтийн үүсвэр: Орон нутгийн хөгжлийн сан

Ашиглагч/ хариуцагч байгууллага: **4-р сургууль**



Ажлын нэр: **152-р байрны гадна тоглоомын талбай байгуулах, тохижилт, авто зогсоолын ажил**

Гүйцэтгэгч байгууллага: **Койот трейд ХХК**

Санхүүжилт: **119,116,627 төгрөг**

Нэмэлт ажлын гэрээ **4,000,000 төгрөг**

Гэрээний дүн: **125,385,923 төгрөг**

Барьцаа: **6,269,296 төгрөг**



2. Ажлын нэр: **4 дүгээр сургуулийн спорт заалны цахилгаан монтаж**

Гүйцэтгэгч байгууллага: **“Энхжих формат” ХХК**

Санхүүжилт: **8,800,000 төгрөг**

Гэрээний дүн: **8,800,000**

Ашиглагч/ хариуцагч байгууллага: **4 дүгээр сургууль**



3. Ажлын нэр: **Суманд интернэт тавих ажил**

Гэрээний дүн: **5,000,000 төгрөг**

Ашиглагч/ хариуцагч байгууллага: **ЗДТГ**

Гүйцэтгэгч байгууллага: **“Их Зэст хөгжил” ХХК**

Санхүүжилт: **5,000,000 төгрөг**

ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

4. Ажлын нэр: **Соёлын төвийн цэвэр бохир усны шугам тавих ажил**

Гүйцэтгэгч байгууллага: **Чадварлаг залуус бүлэг"**

Санхүүжилт: **7,000,000**

Гэрээний дүн: **7,000,000**

Ашиглагч/ хариуцагч байгууллага: **Соёлын төв**



5. Ажлын нэр: **Эрүүл мэндийн төвд түргэвчилсэн оношлогооны тоног төхөөрөмж худалдан авах**

Гүйцэтгэгч байгууллага: **Тавин ус ХХК**

Санхүүжилт: **3,000,000**

Гэрээний дүн: **3,000,000**

Ашиглагч/ хариуцагч байгууллага: **Эрүүл мэндийн төв**



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн төсвийн тодотголоор дараах ажлуудыг хийхээр баталсан. Үүнд:

6. Ажлын нэр: **Цэцэрлэгийн зөөлөн эдлэл**

Гүйцэтгэгч байгууллага: **1-р багийн иргэн Л.Энхтуяа**

Санхүүжилт: **2,500,000 төгрөг**

Гэрээний дүн: **2,500,000 төгрөг**

Ашиглагч/ хариуцагч байгууллага: **4-р цэцэрлэг**

7. Ажлын нэр: **4-р сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл**

Гүйцэтгэгч байгууллага: **1-р багийн иргэн Л.Энхтуяа**

Санхүүжилт: **3,725,000 төгрөг**

Гэрээний дүн: **3,725,000 төгрөг**

Ашиглагч/хариуцагч байгууллага: **4-р сургууль**



ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

8. Ажлын нэр: **4-р сургуульд сандал ширээ худалдан авах**
Гүйцэтгэгч байгууллага: **Хөгжих Лүн Тал ХХК**
Санхүүжилт **6,600,000**

Гэрээний дүн: **6,600,000**
Ашиглагч/ хариуцагч байгууллага: **4-р сургууль**



9. Ажлын нэр: **4-р цэцэрлэгт бүлгийн тоглоом худалдан авах**
Гүйцэтгэгч байгууллага: **Эрхэм мөнх ХХК**
Санхүүжилт: **5,000,000**

Гэрээний дүн: **5,000,000**
Ашиглагч/ хариуцагч байгууллага: **4-р цэцэрлэг**



10. Ажлын нэр: **2-р багт барих багийн төвийн ажлын зураг төсөв**
Гүйцэтгэгч байгууллага: **Сталь-3003 ХХК**
Санхүүжилт: **2,400,000 төгрөг** /2018 оны 4 дүгээр сарын байдлаар/

Гэрээний дүн: **4,800,000 төгрөг**
Ашиглагч/хариуцагч байгууллага: **ЗДТГазар**

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын багцаас манай суманд 2017 онд хэрэгжсэн ажлууд:

11. 4-р сургуулийн спорт заалны засварын ажил:
Төсөвт өртөг: 40,000,000 төгрөг



12. Соёлын төвийн дээвэр засварын ажил:
Төсөвт өртөг: 40,000,000 төгрөг

ОНХСангийн хөрөнгөөр Сумын аюулгүй нөөцөд өвс,
тэжээлийн нөөц бүрдүүлэлт
Төсөвт өртөг: 5,000,000 төгрөг
Гүйцэтгэгч байгууллага: Далай дартан ХХК



ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Аймгийн ИТХ, сумын ИТХ, ЗДТГ-аас 2017 оны 2-р сарын 7-ны өдөр 80 тонн нүүрсийг хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр эрхлээгүй, ахмад настан болон гэр хорооллын айл өрхүүдэд 1 тонн нүүрсийг 3.000 төгрөгөөр тооцож олгох ажлыг амжилттай зохион байгууллаа. Үүнд:

36 өрх – 2 тн

1 өрх – 1 тн

Нийт 37 өрх айл хамрагдлаа.



“Баянтал сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн биелэлтийг хангах ажлын хүрээнд 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдөр 4-р сургуулийн сурагчдын дунд “Засаг даргын нэрэмжит математикийн олимпиад”-ыг зохион байгууллаа. Тус олимпиадыг зохион байгуулахад Засаг даргын Тамгын газраас 100,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээ.



2017 оны 02 дугаар сарын 17 -нд Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэрэмжит "Монгол хэлний олимпиад" 4-р сургуулийн дунд ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга С.Басан, ИТХ-ийн ажлын албаны дарга Л.Лхагвасүрэн нар шагналыг гардууллаа.



Сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ний А/31 тоот захирамжаар “Эх үрс”-ийн баярын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Баярын арга хэмжээг сумын Засаг дарга нээж аймгийн удирдлагууд болон УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг ирж баярын үйл

ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

ажиллагаанд оролцсон. Энэ удаагийн баярыг “Хүүхэд бүрийг баярлуулъя” уриан дор тэмдэглэж ЗДТГ, Аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран сумын 400 хүүхдэд бэлэг гардуулан дугуйн уралдаан болон хөгжөөнт тэмцээн зохион байгууллаа. “Хилийн дэлгэрэх” ХХК 10 хүүхдэд, “Сайжирна” хүнсний дэлгүүр 10 хүүхдэд, ХХҮГ, Мөн алдарт эхийн одонгоор шагнуулсан 7 эхчүүдэд хүндэтгэл үзүүллээ.



2017 оны 10 сарын 01-ний өдрийн ахмадын баярыг сумандаа зохион байгуулж хүндэтгэл үзүүллээ. Сумын хэмжээнд нийт 94 өндөр настан байна. Үүнээс харьяалалгүй 48 ахмадыг байгууллагад хувиарлан өгч хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа.



Сумын удирдлагууд Шивээ говь ХХК-тай хамтран 2017 оны 12 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд сумын зорилтот бүлгийн 41 айл өрхөд хөнгөлттэй үнээр 80 тонн нүүрс тарааж дэмжлэг үзүүллээ.



2017 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Сумын Засаг даргын нэрэмжит “Сумын аварга” шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Нийт 12 баг тамирчид оролцлоо.



ТОСТ БОРЖИГОНЫ ТОРГОН ХОЙМОР

Сумын 1 дүгээр багийн Засаг дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нар хамтран 4 дүгээр сургуулийн 6, 7, 8 дугаар ангийн нийт 35 хүүхдэд “Хог хаягдлын тухай” хууль болон “Хүүхэд хамгааллын тухай” хуулиар сургалт зохион байгууллаа.



Сумын Засаг даргаар батлуулан удирдамжийн дагуу ажлын хэсэг Сургууль, Цэцэрлэгийн үдийн цайны хэрэгжилт, гал тогоо болон тогоочийн ариун цэвэр, цэвэрлэгээ үйлчилгээ, эрүүл ахуйн стандартыг дагаж мөрдөж байгаа эсэх, хүнсний бүтээгдэхүүний хугацаа болон гарал үүслийн бичигтэй эсэх, гал тогоо болон няравын агуулах саванд тус тус дотоод үзлэг шалгалтыг явуулж ажиллалаа. Зөвлөн туслах ажиллагааг 2017 онд нийт 3 удаа зохион байгуулсан.



2018 оны 02 дугаар сарын 10-ны өдөр сумын “Соёлын төвөөс” “Таван эрдэнэ” теле уралдааныг төрийн байгууллагуудын дунд зохион байгуулж, нийт 54 албан хаагч авхаалж самбаагаа сорьлоо. Уг арга хэмжээг ТҮ-9 телевизийн Говьсүмбэр аймаг дахь салбартай хамтран зохион байгууллаа.



2018 оны 02 дугаар сарын 11-ний өдөр УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг 70-аас дээш настай өндөр настангуудыг хүндэтгэж өгсөн гарын бэлгийг уламжлан ахмадууддаа гардууллаа.



Байгаль орчны хүрээнд 2017 онд хийгдсэн ажлууд

1. Баянтал сум 2017-01-04-ны өдөр иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын дунд “Хог хаягдлын менежмент” сэдэвтэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Хог хаягдлын тухай хуулиар мэдээлэл хийсэн ба сумын хэмжээний туурь хог болон ахуйн хог хаягдлаас хэрхэн ангижрах талаар иргэд, аж ахуй нэгж байгууллагуудтай санаа бодлоо хуваалцан тулгамдаж буй асуудлуудаа шийдэн иргэн С.Батмөнхтэй хог хуримтлуулах цэгүүдээс 7 хоног бүр хогийг ачиж төв хогийн цэгт асгаж байхаар гэрээ байгуулан ажиллаж байгаа ба “Цэмцгэр Баянтал” уриан дор иргэн, аж ахуй нэгж байгууллагууд хамтран бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол хийж хэвшсэн.



2. “Цэмцгэр Баянтал” уриан дор иргэн, аж ахуй нэгж байгууллагад цэвэрлэх хэсэг бүрийг план зураг дээр хувиарлалт хийн сар бүрийн сүүлийн долоо хоногийн 4 дэх өдөр болгоны 16 цагт хийхээр хувиар гаргасан. Нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагууд хувиарийн дагуу тогтмол цэвэрлэгээ хийж хэвшсэн. Сар бүр цэвэрлэгээ хийхдээ нийт 18 тнн хог хаягдлыг цэвэрлэн төв хогийн цэгт асгасан.



3. Төв хогийн цэгийн хогийг “Чойр хайрхан” ХХК болон "Талын илч" ОНӨҮГазартай хамтран түрж булсан.



4. Эргүүл шалгалтын ажил зохион байгуулах Аймгийн засаг даргын 2017оны 3 дугаар сарын 31-ны өдрийн А/96 тоот захирамжаар эргүүл шалгалт хийх хувиарын дагуу 2017оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Газрын даамал БОБ, 2дугаар багийн засаг дарга, хэсгийн төлөөлөгч, олон нийтийн цагдаа нарын бүрэлдэхүүнтэй Босгон, 2толгой, Шилийн худаг, Их уул, 2 цагаан худаг, Тэрэгт, Цэрдгэр гэсэн маршрутаар эргүүл шалгалт хийсэн. Эргүүл шалгалтаар 9 малчин өрхөөр орж хээрийн түймэр, хууль бус ан агнуурын талаарх хууль тогтоомж, гарсан захирамж шийдвэрийн талаарх мэдээллийг малчид иргэдэд өгч санал бодлыг сонсож хамтран ажиллахаар болсон.



5. Монгол улсын Ойн тухай хууль болон Монгол улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 63 дугаар зарлигийн хүрээнд орон даяар жил бүр бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан “Иргэн бүр нэг мод тарьж ургуулах хөдөлгөөн”-ийг зохион байгуулсан. 4 дүгээр сарын 28-ны өдөр мод тарих талбайн хог хаягдлыг цэвэрлэж, урьд онуудад тарьсан моднуудыг усалж, арчилгаа тордолгоог хийсэн. 5 дугаар сарын 3-нд БОАЖГазраас зохион байгуулсан “Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа”-аас захиалсан тарьц суулгацаа хүлээн авч сумын аж ахуй нэгж байгууллага 300 ширхэг мод, УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг 100 ширхэг шар хуайс, Байгаль орчин ногоон хөгжлийн яам Ойн бодлого зохицуулалтын газраас 200 ширхэг хайлаас мод, 1-р багийн иргэн Уранчимэг хайлаас, агч буйлс зэрэг 180 ширхэг модыг өгч цэцэрлэгт хүрээлэнд тарьлаа. Нийт сумын хэмжээнд бүх нийтээр мод тарих аяныг угтан 780 ширхэг мод тарьлаа. Мод тарих ажилд ЗДТГазар, Эмнэлэг, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Талын-Илч ОНӨУГазрын, ахмадууд албан хаагчид оролцлоо.



6. Монгол улсын Байгаль орчин, Аялал жуулчлалын яамнаас зохион байгуулж буй “Цэвэр сайхан орчин аян”-ны хүрээнд аймгийн засаг даргын 2017.06.07 А/179 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдаж сарын хугацаанд аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө батлах хуралд суусан.

7. “Цэвэр сайхан орчин” аяны хүрээнд сумын төвийн баруун гэр байрны ахуйн хог хаягдлын 0,1га талбайн хогийг “Талын илч”ОНӨҮГ-аартай хамтран түрж булж газрыг тэгшлэн цэвэрлэсэн.



8. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ЗДТГ-ын хамт олон гар доорхи материалаа ашиглан хогийн сав хийж төв талбай дээрээ байршуулан “Хогоо хогийн саванд” уриатайгаар баяраа тэмдэглэн өнгөрүүлээ.

9.

9. Аймгийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/352 тоот захирамжаар байгуулагдсан Говьсүмбэр аймгийн аж ахуй нэгжүүдийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ий хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүн хамтран 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Баянтал сумалд үйл ажиллагаа явуулж байгаа “Чойр хайрхан” ХХК болон Талын илч ОНӨҮГ-ын үйл ажиллагаатай танилцан 2016 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.



Сумын төвийн агропаркийн нурсан хашааг ЗДТГ-ын ажилчидтай хамтран засаж сэлбэн, доторхи хогийг цэвэрлэн, ногоо тарих талбайг хагалж бэлтгэсэн.

